

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.08.13-08.17

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд лхагва гарагт огцом унаж, харин пүрэв гарагт буцаад өсчээ. S&P 500 индексийн сагсанд багтдаг өргөн хэрэглээний бараа үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш өсөлттэй хаагдсан бол үл хөдлөх хөрөнгө болон харилцаа холбооны салбарт үйл ажиллагаагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш унасан үзүүлэлттэй байв.

АНУ-ын газрын тосны нөөц нэмэгдсэнээр газрын тосны ханш суларч, тус салбарт үйл ажиллагаа эрхэлдэг компаниудын хувьцааны ханш унасан байна.

Хөрөнгө оруулагчид Туркийн лирийн ханш эрс суларч, хөгжиж буй орнуудын эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж магадгүй хэмээн үзжээ.

Пүрэв гарагт БНХАУ-ын худалдааны асуудал эрхэлсэн төлөөлөгчид АНУ-ыг зорьж байгаа талаар мэдээлэл гарч, зах зээлийн индексүүд өсжээ.

АНУ-ын Худалдааны яамны мэдээлснээр 7-р сард тус улсын жижиглэнгийн худалдаа 0.5%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Жижиглэнгийн худалдааны салбарт үйл ажиллагаагаа явуулдаг "Walmart" компанийн хагас жилийн санхүүгийн тайлан гарчээ. Интернет худалдаа нэмэгдсэнээр тус компани борлуулалт сүүлийн 10 гаруй жилд үзэгдээгүй их хэмжээнд хүрсэн байна. Ингэснээр тус компанийн хувьцааны ханш 9%-аар өсчээ.

Европ: Итали улсын банкуудын тогтвортой байдал, Туркийн мөнгөн тэмдэгийн сулрал болон дэлхийн худалдааны тодорхой бус байдал зэрэг нь Европын хөрөнгийн зах зээлийн индекст сөргөөр нөлөөлжээ. Лирийн ханш суларсаар байгаа нь тус улсын томоохон зээлдэгч болох Италийн "UniCredit", Испанийн "BBVA", Францын "BNP Paribas" зэрэг банкуудын санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлж байгаа аж.

Япон: Энэ долоо хоногт Японы компаниудын хувьцааны ханш хэлбэлзэл ихтэй байж уналттай хаагдлаа. Иенийн ханш бага зэрэг чангарч ам. долларын эсрэг 110.4 болжээ.

Японы хувьцаат компаниудын нийт цэвэр ашиг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 28 хувиар буюу 80 тэрбум ам.доллараар нэмэгдсэн байна. Nikkei сонины мэдээлснээр Японы 1,588 хувьцаат компанийн 56 хувь нь ашигтай ажиллажээ.

БНХАУ: "Bloomberg" агентлагийн мэдээлснээр БНХАУ, АНУ хоорондын худалдааны маргаан даамжирч, БНХАУ-ын Төв банк тус улсын эдийн засгийг дэмжих зорилгоор мөнгөний бодлогоо зөөлрүүлсэн нь юанийн ханшийг энэ оны 3-р сараас хойш ам. долларын эсрэг 8 орчим хувиар сулрахад нөлөөлжээ.

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширч, тус улсын томоохон технологийн "Tencent" группын хувьцааны ханш огцом унасан байна.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,263.81	0.64% ▼
Dow Jones	АНУ	25,669.32	1.41% ▲
S&P 500	АНУ	2,850.13	0.59% ▲
Nasdaq	АНУ	7,816.33	-0.29% ▼
S&P/TSX	Канад	16,323.71	-0.02% ▼
FTSE 100	Их Британи	7,558.59	-1.41% ▼
S&P/ASX 200	Австрали	6,339.20	0.97% ▲
Nikkei 225	Япон	22,270.38	-0.12% ▼
Hang Seng	Хонг Конг	27,213.41	-4.07% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	110.08
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	97.10
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	96.48
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	113.10
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.36
TDBM' 2020	USD	9.3%	106.40

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.069	0.00 ▲
Libor 3M	2.312	-0.01 ▼
Libor 6M	2.511	-0.00 ▼
Libor 1YR	2.813	-0.00 ▼
US 6M Bond	2.219	0.01 ▲
US 2YR Bond	2.608	0.02 ▲
US 3YR Bond	2.681	0.02 ▲
US 5YR Bond	2.745	0.02 ▲
US 10YR Bond	2.866	0.01 ▲

Валютын ханш /төг/

Валют	2018.08.17	Өөрчлөлт
USD	2,464.56	0.35% ▲
CNY	357.78	-0.13% ▼
EUR	2,806.64	-0.33% ▼
RUB	36.85	0.27% ▲
KRW	2.19	0.92% ▲
JPY	22.26	0.32% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,183.19	-2.10% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	14.76	-3.40% ▼
Зэс	USD/lb.	267.25	-2.14% ▼
Нүүрс	USD/MT	107.85	1.08% ▲
WTI газрын тос	USD/bbl.	65.81	-2.56% ▼
Brent газрын тос	USD/bbl.	71.7	-1.21% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	2.92	0.00%

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. VII	7.70%
Бодлогын хүү	2018. VII	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. VI	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. VI	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. VI	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. VI	18.00%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. VI	10.20%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 38 компанийн 350.5 сая төгрөгийн 1,744,422 ширхэг хувьцаа арилжигдав.

“Ган хэрлэн” /HZB/ компанийн хувьцаа 14.98%-аар буюу хамгийн ихээр өсч 3,838 төгрөгт хүрч хаагдсан бол “Монгол шилтгээн” /MSH/ компанийн хувьцаа 16.48%-аар буурч 400 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


8-р сарын 17-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,335.9 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,263.81 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.64%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	350.5
Зах зээлийн үнэлгээ	2,335,940.2

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,263.81	-0.64% ▼
MSE I индекс	9,362.63	-1.04% ▼
MSE II индекс	9,230.57	-0.53% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛэндМН ББСБ	1,398,243	97,177,365
Ган хэрлэн	15,000	57,570,000
АПУ	76,511	45,022,607
Говь	1,512	38,057,600
Таван Толгой	3,779	30,409,560

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Ган хэрлэн	3,838.00	14.98% ▲
Хөсөг трейд	1,890.00	14.96% ▲
Адуун чулуун	2,200.00	9.95% ▲
Улсын их дэлгүүр	489.99	8.89% ▲
Тээвэр дархан	13,000.00	1.17% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Монгол шилтгээн	400.00	-22.22% ▼
Ноёт хайрхан	600.00	-13.79% ▼
Эрдэнэт авто зам	750.00	-10.00% ▼
Жинст-Увс	1,460.00	-10.00% ▼
Баянгол зочид буудал	28,000.00	-6.67% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Монсек	132,414,581
Бумбат-Алтай	98,423,000
Ти Ди Би Капитал	91,581,435
Голомт Капитал	61,217,850
БиДиСек	55,344,277

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	580.25	617,491
Таван толгой	8,200.00	431,855
МИК	10,980.00	227,388
Говь	24,980.00	194,872
Сүү	218.99	75,333

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр	Хуваарилах хэлбэр
1	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
2	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
3	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
4	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с	Тодорхойгүй
5	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
6	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с	Тодорхойгүй
7	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
8	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй	Тодорхойгүй
9	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй	Тодорхойгүй
10	SUL	Жуулчин дюти фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с	Компанийн байранд
11	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с	Тодорхойгүй
12	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с	Компанийн байранд
13	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
14	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
15	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
16	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор	Тодорхойгүй
17	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
18	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
19	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с	Компанийн байранд
20	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с	Компанийн байранд
21	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй	Тодорхойгүй
22	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
23	TAN	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
24	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с	ҮЦТХТ-ийн данс
25	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов	Компанийн байранд
26	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Би Ди Сек ҮЦК” ХК-ийн үнэт цаасны ангиллыг ахиуллаа

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 20 дугаар зүйлийн 20.2, 20.3.6 дахь заалтууд болон ангилал ахиулах тухай “Би Ди Сек” ХК-ийн 18/314 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт зэргийг тус тус үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн А/92 тоот тушаалаар “Би Ди Сек ҮЦК” ХК-ийн үнэт цаасыг “II” ангиллаас ахиулан “I” ангилалд бүртгэлээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тойм

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь 2018 оны эхний хагас жилд нийт 126 удаагийн арилжаа зохион байгуулж, хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 128 компанийн 384.5 сая ширхэг хувьцааг 49.5 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 276 мянган ширхэг үнэт цаасыг 27.5 тэрбум төгрөгөөр, компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 6,316 ширхэг “Сүү бонд”-ыг 631.6 сая төгрөгөөр тус тус арилжиж, нийт 77.5 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн байна.

Тайлант хугацаанд МХБ нь хагас жилийн хугацаанд хамгийн олон буюу 3 компанийн үнэт цаасыг шинээр бүртгэж, анхдагч зах зээлд нийт 13.9 тэрбум төгрөгийн арилжаа хийсний зэрэгцээ Канад улсад бүртгэлтэй компани Монголын хөрөнгийн биржид хувьцаагаа бүртгүүлснээр үнэт цаасны давхар бүртгэл хөрөнгийн зах зээлд нэвтэрсэн зэрэг онцлог үйл явдлууд боллоо.

Санхүүгийн үзүүлэлтийн хувьд тайлант хугацаанд Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй хэдий ч нийтдээ 793.7 сая төгрөгийн орлого олж, 897.3 сая төгрөгийн зардалтай ажилласан бөгөөд улсын төсөвт нийт 219.7 сая төгрөгийн татвар, шимтгэл төлсөн байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Айтүүлс” ХК 2018 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа

Монголын хөрөнгийн биржийн 2-р ангилалд бүртгэлтэй, мэдээлэл технологийн “Айтүүлс” ХК нь 2018 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа олон нийтэд нээлттэй танилцууллаа.

2018 оны эхний хагас жилд “Айтүүлс” ХК-ийн нийт борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 39.4 хувиар өсч, 439.3 сая төгрөгт, цэвэр ашгийн хэмжээ 3 дахин өсч өсч, 62.4 сая төгрөгт тус тус хүрсэн үзүүлэлттэй байна.

Дархан хот дахь дата төвийн барилгын ажил 2021 он хүртэл хойшилсон тул тус компани “Санхүүгийн дата төв” төслийг хэрэгжүүлж байна. Үүний зэрэгцээ “Айтүүлс” ХК нь блокчейн технологид суурилсан UBEX арилжааны платформ, Zeel.mn, Trade.mn, клоудмайнинг зэрэг төслүүд дээр ажиллаж байгаа аж. Энэ ажлын хүрээнд Япон улсад крипто валют олборлох болон блокчейн технологид суурилсан үйлчилгээнүүдийг үзүүлэхээр болсон байна.

Түүнчлэн “Айтүүлс” ХК нь Үндэсний дата төвтэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр хамтарч ажиллаж эхэлжээ.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК

“Дархан нэхий” ХК 2018 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй “Дархан Нэхий” ХК нь 2018 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа олон нийтэд нээлттэй танилцууллаа.

2018 оны эхний хагас жилд “Дархан Нэхий” ХК-ийн цэвэр борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.5 хувиар буурч, 5.3 тэрбум төгрөгт хүрсэн ч компанийн зүгээс оны эцэс гэхэд борлуулалтыг өмнөх оноос 44 хувиар өсгөх зорилт тавин ажиллаж байгаагаа мэдэгдлээ. Энэхүү зорилтын хүрээнд үйлдвэрлэлийн хүчин чадлаа өргөжүүлж, үстэй боловсруулах шугамыг суурилуулах, нэхий боловсруулах явцад хаягдал болдог ноосыг угаах автомат үйлдвэрийг ашиглалтанд оруулснаас гадна энэ ондоо багтаан 100,000 ширхэг эко арьсыг Европ уруу экспортлохоор ажиллаж байна.

Компани үйлдвэрлэлийн хаягдлыг бууруулж, эко үйлдвэрлэл эрхлэх чармайлт гарган усны болон химийн материалын дахин ашиглалтыг арьс шир боловсруулах үйлдвэрүүддээ нэвтрүүлсэн байна. Цаашид усны дахин ашиглалтыг 80-90%-д хүргэх, шохойны дахин ашиглалтыг оруулах, гарч байгаа халимаа дахин ашиглаж арьсны боловсруулалтын дэвтээлэг, угаалгын шатанд ашиглах саванг туршилтын журмаар гаргасан байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Монгол базальт” ХК 2018 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа

Монголын хөрөнгийн биржийн 2-р ангилалд бүртгэлтэй “Монгол Базальт” ХК нь 2018 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа олон нийтэд нээлттэй танилцууллаа.

2018 оны эхний хагас жилд “Монгол Базальт” ХК-ийн борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.4 хувиар буурч 639.4 сая төгрөгт хүрч, 190.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Компани нь олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөс үнэт цаасны танилцуулгад тусгасны дагуу урт хугацаат зээлээ бүрэн төлж дуусгасан ба одоогийн байдлаар тоног төхөөрөмж шинээр худалдан авалгүй хадгаламжинд байршуулснаар 42.6 сая төгрөгийн хүүгийн орлого олжээ. Энэ оны 9-10-р сараас тус компани галд шатдаггүй шүрдэг базальт хөвөн, базальт хавтанг зах зээлд нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Борлуулалт, маркетингийн зардал огцом өсөхөд IPO гаргахтай холбоотой 423.8 сая төгрөгийн үнийн дүн бүхий нэг удаагийн зардлууд голчлон нөлөөлсөн хэмээн “Монгол базальт” ХК-ийн зүгээс мэдээлсэн.

“Монгол базальт” ХК одоогийн байдлаар чулуун хөвөн худалдах 1.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 2 гэрээ шинээр байгуулсан, мөн 1.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 2 гэрээг байгуулах нь тодорхой болсон ба 2.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 2 гэрээ хүлээгдэж байгаа талаар мэдээлсэн. Мөн тендерт оролцох боломж нээгдсэн ажээ.

Цаашид үндсэн бүтээгдэхүүнүүдийн чанарын удирдлагын тогтолцоог сайжруулах, борлуулалтын хэмжээг 2022 он хүртэл жил бүр 45 хувиар нэмэгдүүлэх, гадаад зах зээлд нэвтэрч BASALTWOOL брендийг бий болгоход анхаарч ажиллана хэмээн компанийн зүгээс мэдэгдлээ. Энэхүү ажлын хүрээнд тус компани маркетингийн зардлаа нэмэх төлөвлөгөөтэй байна.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК

БУСАД МЭДЭЭ

ҮСХ: Монголын эдийн засгийн 7-р сарын байдал

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2018 оны эхний хагас жилд урьдчилсан гүйцэтгэлээр 8.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 475.2 (6.3%) тэрбум төгрөгөөр өслөө. Уг өсөлтөд үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 184.9 (5.8%) тэрбум төгрөг (бөөний болон жижиглэн худалдааны салбарын нэмэгдэл өртөг 73.7 тэрбум төгрөг буюу 9.0%), бүтээгдэхүүний цэвэр татвар 192.1 (21.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

ДНБ, оны үнээр 2018 оны эхний хагас жилд урьдчилсан гүйцэтгэлээр 15.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.1 (16.0%) их наяд төгрөгөөр өслөө. Улирлын нөлөөллийг арилган тооцсоноор ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2018 оны 2 дугаар улиралд өмнөх улирлаас 1.8 хувиар өслөө.

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2018 оны 7-р сарын эцэст 17.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 153.5 (0.9%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 3.2 (22.8%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2018 оны 7-р сарын эцэст 917.1 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 14.0 (1.5%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 29.5 (3.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 7-р сарын эцэст 15.6 их наяд төгрөг болж, өмнөх сараас 192.5 (1.3%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 2.6 (19.6%) их наяд төгрөгөөр өсөв.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2018 оны эхний 7 сарын байдлаар 5.0 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 4.8 их наяд төгрөгт хүрлээ. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2017 оны эхний 7 сард 589.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч байсан бол 2018 оны эхний 7 сард 291.3 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Татварын нийт орлого 4.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.1 (33.0%) их наяд төгрөгөөр өсөхөд нэмэгдсэн өртгийн албан татвар 291.6 (34.1%) тэрбум төгрөг, орлогын албан татвар 277.7 (31.5%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 168.4 (68.5%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 145.0 (20.5%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 108.5 (33.0%) төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 102.8 (39.0%) тэрбум төгрөг төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 79.6 хувийг татварын орлого, 10.3 хувийг татварын бус орлого, 7.3 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 2.8 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна.

Монгол Улс 2018 оны эхний 7 сард 143 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 7.4 тэрбум америк доллар, үүнээс экспорт 4.1 тэрбум америк доллар, импорт 3.3 тэрбум америк долларт хүрлээ.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.5 (26.2%) тэрбум америк доллар, үүнээс экспорт 596.4(16.9%) сая америк доллараар, импорт 935.1 (40.1%) сая америк доллараар тус тус өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл 2017 оны эхний 7 сард 1.2 тэрбум америк долларын ашигтай гарч байсан бол 2018 оны эхний 7 сард өмнөх оны мөн үеэс 338.7 (28.5%) сая америк доллараар буурч, 851.0 сая америк долларт хүрчээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 7 дугаар сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.5 хувь, өмнөх оны эцсээс 5.5 хувь, өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 11.1 хувь (төмс, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 45.0 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 6.6 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 10.7 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 9.2 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 6.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 14.9 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 22.1 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 11.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



World Economics: Монгол Улсын борлуулалтын менежерүүдийн индекс сүүлийн 4 сарын доод түвшинд хүрээд байна

8-р сард Монгол Улсын борлуулалтын менежерүүдийн индекс буурч, 58.3 нэгж болсон талаар "World Economics" байгууллага мэдээллээ. Өөрөөр хэлбэл энэхүү индекс сүүлийн дөрвөн сар орчмын доод түвшинд хүрээд байгаа юм. Үүнийг "World Economics" байгууллага баяр наадамтай холбон тайлбарлаж байна. Наадам дөхөхтэй зэрэгцээд Монгол Улсын борлуулалтын менежерүүдийн индекс огцом өсч, 60 нэгжийг даваад байсан ч 7-р сараас хойш эргэн 50 нэгж рүү унаад байгаа юм. 2018 он гарснаас хойш бизнесийн итгэлийн индекс өсөлтийн бүсэд хадгалагдаж байгааг тус судалгааны байгууллага онцолж байна. Өөрөөр хэлбэл цаашид бизнесийн орчин сайжирна гэсэн хүлээлт зах зээлд өндөр байгаа юм. Эдийн засгийн бусад үзүүлэлтүүдийг харвал инфляци 8-р сарын байдлаар 6.3 хувьтай гарсан нь өмнөх улиралтай харьцуулахад өссөн дүн болжээ. Монголбанкны үзэж байгаагаар инфляци энэ онд зорилтот түвшин болох найм орчим хувьд тогтворжих төлөвтэй байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.